

БАТЛАВ:
БОУАӨЯ-НЫ ЕРӨНХИЙ ШИНЖЭЭЧ

/Г.ЭНХМӨНХ /

“ИРМҮҮН ОЙЛ ТРЕЙДИНГ”ХХК-ИЙН
ЗАХИРАЛ

/Д.ЭРДЭНЭБАТ/

**УЛААНБААТАР ХОТЫН СОНГИНОХАЙРХАН ДҮҮРЭГТ
ОРШИХ “ХАЯГДАЛ ТОС ЦУГЛУУЛАХ, ТЭЭВЭРЛЭХ,
ХАДГАЛАХ, ДАХИН БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭР”-ИЙН
2024 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

Аж ахуйн нэгжийн регистрийн дугаар: 6666612

ХЯНАСАН:

БОУАӨЯ-НЫ ХБОБЗГ-ЫН АХЛАХ ШИНЖЭЭЧ

/...../

БОЛОВСРУУЛСАН:

БАЙГАЛЬ ОРЧНЫ МЭРГЭЖИЛТЭН:

А.ОТГОНБААТАР

Улаанбаатар хот
2024 он

ГАРЧИГ

ГАРЧИГ	2
1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА БОЛОН ХОЛБОГДОХ МЭДЭЭЛЭЛ.....	4
1.1 Төслийн ерөнхий мэдээлэл:	4
2. ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧИНД НӨЛӨӨЛӨХ БАЙДАЛ, ТҮҮНИЙ ҮНЭЛГЭЭ	9
3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ	12
4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ 2024 ОНЫ ГОЛ ЗОРИЛТ	13
5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	14
6. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	15
7. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ..	15
8. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	16
9. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	16
10. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР	18
11. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ	19
12. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ	20

Зургийн жагсаалт

Зураг 1. Төслийн талбайн байршил.....	5
Зураг 2. Үйлдвэрийн тоног төхөөрөмж, технологийн схем.....	7
Зураг 3. Үйлдвэрийн харагдах байдал	8
Зураг 4. Үйлдвэрийн үндсэн тоног төхөөрөмж.....	8
Зураг 5. Үйлдэрийн түүхий эд болон эцсийн бүтээгдэхүүн хадгалах савнууд.....	8

ОРШИЛ

Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний эрх бүхий “Ашид таван эрдэнэ” ХХК-аар Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүрэгт “Ирмүүн ойл трейдинг” ХХК-ийн “Хаягдал тос цуглуулах, тээвэрлэх, хадгалах, дахин боловсруулах үйлдвэр” төслийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг хийж гүйцэтгүүлсэн ба мэргэжил арга зүйн зөвлөгөө авсны үндсэн дээр 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний ажлыг хийж гүйцэтгэлээ.

Энэхүү ажлыг гүйцэтгэхдээ “Байгаль орчныг хамгаалах тухай”, “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай”, “Усны тухай” хуулиуд, Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2014 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн А-05 дугаар тушаалаар баталсан Иргэн, аж ахуйн нэгж байгууллагын тухайн жилд хэрэгжүүлэх “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам” болон Байгаль орчин, аялал жуулчлалын яамны шинжээчийн гаргасан ерөнхий үнэлгээний дүгнэлт, нарийвчилсан үнэлгээ зэргийг үндэс болгов.

Төслийн гол зорилго нь төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд учруулах сөрөг нөлөөллийг тодорхойлох, түүнийг бууруулах, арилгах арга хэмжээ, шаардагдах хөрөнгө зардлыг төлөвлөх, үйлдвэрийн бүх шат дамжлага бүрд нөлөөлөл бууруулах зөвлөмж боловсруулах, үйл ажиллагааны явцад мөрдөж ажиллах байгаль орчны менежментийн төлөвлөгөө, орчны хяналт, шинжилгээний хөтөлбөр боловсруулах зэрэг нь зайлшгүй шаардлагатай юм.

1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА БОЛОН ХОЛБОГДОХ МЭДЭЭЛЭЛ

1.1 Төслийн ерөнхий мэдээлэл:

Төслийн нэр: “Хаягдал тос цуглуулах, тээвэрлэх, хадгалах, дахин боловсруулах үйлдвэр” төсөл.

Төслийн зорилго: Шинэ техник технологи бүхий дэвшилтэд тоног төхөөрөмжийг эх орондоо нэвтрүүлж аюултай хог хаягдлыг дахин боловсруулан эдийн засгийн эргэлтэд оруулах замаар газрын тосны салбарт хэрэглэгчийн хүсэл шаардлагад нийцсэн шингэн түлш “Мазут” нийлүүлэх явдал юм.

Төсөл хэрэгжүүлэх аж ахуйн нэгжийн нэр:

“Ирмүүн ойл трейдинг” ХХК, регистрийн дугаар 6666612, улсын бүртгэлийн дугаар 9011824921.

Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг:

Улаанбаатар хот. Хан-Уул дүүрэг 11-р хороо, 2 хэсэг, Тэнгэр рашаан, 79в тоот. Утас: 99119328.

Төслийн байршил, хэрэгжих орчны тойм зураг:

Төсөл хэрэгжиж буй газар нь Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн 20-р хороонд байрладаг. “Хаягдал тос цуглуулах, тээвэрлэх, хадгалах, дахин боловсруулах” төсөл нь үйлдвэрийн районд байрладаг бөгөөд эргэн тойронд нь аж ахуй нэгжүүдийн эзэмшлийн газруудтай, гэр хорооллын суурьшлийн бүсээс зайтай, эргэн тойронд айл өрх байхгүй. “Ирмүүн Ойл Трейдинг” ХХК-ийн Захирал Д.Эрдэнэбатын эзэмшлийн газар нь 0.4 га бөгөөд тухайн газарт асфальт замын гол түүхий эд болох битум үйлдвэрлэдэг “Монгол битум” ХХК байрладаг. “Хаягдал тос цуглуулах, тээвэрлэх, хадгалах, дахин боловсруулах” төсөл нь газрын урд хэсэгт 212 м.кв талбайд үйл ажиллагаа явуулдаг.



Зураг 1. Төслийн талбайн байршил

Үйлдвэрийн технологи

Хаягдал тосыг дахин боловсруулах процесс нь газрын тосны хаягдлыг дулааны аргаар дахин боловсруулах технологи юм. Техникийн хаягдал тосыг нэрлэгийн аргаар ууршуулж Мазут үйлдвэрлэх бөгөөд вакуумжуулалтын аргаар тосон дахь бусад нэгдлүүдийг конденсатчилах (шингэн төлөвт оруулах) юм.

-Хүчилтөрөгчийг цагирагт нүүрстөрөгчтэй нэгдүүлэх: Хүчил төрөгч устөрөгчтэй нэгдэн ус болоод уурших урвалын явцад Мазут үйлдвэрлэх үндсэн зарчимтай.

Техникийн хаягдал тосны дахин боловсруулалтын явц нь 100-120°С-д тосны бусад нэгдлүүдийг (механик хольц) ууршуулах нь үйлдвэрийн үндсэн технологи юм. Үйлдвэрлэлийн үйл явцын голлох параметрууд нь температур, агаарын сийрэгжилт, конденсатлах үйл явц юм. Температур нь өндөр байх тусам ууршуулах үйл явц хурдан явагдана. Мазутны илчлэг чанар сайн болно. Ихэнхдээ температур 110-120°С байна. Агаарын сийрэгжилт сайн байх тусам конденсатлах үйл явц хурдан явагдана.

Тогтмол температурт ууршуулж байгаа Мазутын агаарын сийрэгжилтийг нэмэгдүүлснээр Мазутын цэвэр чанарыг нэмэгдүүлдэг. “Ирмүүн ойл трейдинг” ХХК-ийн үйлдвэрлэсэн Мазутыг автозамын асфалт завод, битум хайлуулах (үйлдвэрлэх) “Монгол битум” ХХК-д шууд нийлүүлнэ.

Үйл ажиллагааны горим

Тухайн үйлдвэрт дулаан дамжуулагчаар (ус болон уурын оронд) диатермийн тосыг (синтетик болон минералын тосын холимог) ашигладаг болно. Шингэн фазтай халаагч систем ODE нь бүрэн автоматчлагдсан газар эсвэл шингэн түлш (мазут)-аар ажилладаг, дулааны шингэн тос нь атмосферийн даралтад 300°с хэм хүртэл халаах чадалтай, бага габритын халаагч (ODE тогоо)-аас тогтоно. Дулааны КПД агрегат нь 85-87%. Халаасан дулааны шингэн нь битүү орчинд эргэлдэх ба дулааны хэрлэгчийн тогтоосон схемийн дагуу технологийн процессын явцад тохирох дулаан дамжуулагчаар дамжина. ODE халаагч тогоо нь автомат систем болон насос, мазут шатаагч, гал хамгаалагч бэхлэгч зэргээс тогтоно.

Төслийн хүчин чадал

Үйлдвэрийн үндсэн тоног төхөөрөмжийн дээд хүчин чадал 3 ээлжээр, 24 цагийн турш ажиллах боломжтой бөгөөд нэг ээлжинд 40 тонн хоногт 120 тонн хаягдал тос дахин боловсруулах дээд хүчин чадалтай. Үйлдвэрлэл нь дулааны улиралд явагдах ба 11-3 дугаар сарын хугацаанд үйлдвэрлэл зогсоно. “Ирмүүн ойл трейдинг” ХХК нь одоогоор түүхий эдийн нийлүүлэлт, хадгалалт, эцийн бүтээгдэхүүний нийлүүлэлт, хадгалалт зэргээс хамааран төслийн суурилагдсан хүчин чадлын 20%-ийг ашиглан жилд 200 тонн, сард 30-40 тонн Мазут үйлдвэрлэн “Монголбитум” ХХК-д нийлүүлнэ.

Хүснэгт 1. Үйлдвэрийн жилийн хүчин чадал

№	Нэр	Орц		Гарц	
		тн/ жил	хувь	тн/ жил	хувь
1	Түүхий эд	200	100		
2	Мазут			198	99.8
3	Хаягдал			0.4	0.2
4	Бүх жин	200	100	198	100

Үйлдвэрийн тоног төхөөрөмж

Үйлдвэр нь зуухны хэсэг, халаах танк, удирдлагын хэсэг, агуулахын хэсэг гэсэн үндсэн 4 хэсэгтэй ба дараах үндсэн тоног төхөөрөмжүүдтэй. Үүнд:

Халаагч босоо танк

- Ууршуулагч
- Дулаан солилцуур
- Шугам хоолой, хаалт
- Шахах насос
- Бэлэн бүтээгдэхүүн хадгалах сав

- Түүхий эд, материал хадгалах сав
- Шингэн нэгдэл хадгалах (тунадасны сав)
- Хүчдэл тохируулагч инвертер

Техникийн хаягдал тосыг дахин боловруулан шингэн түлш /мазут/ гарган авах техникийн ерөний горим нь дараах шатлалаар явагдах болно.

1-р шат: Реакторт 10 тонн ажилласан масло татна.

2-р шат: Реакторт татсан түүхий эдийг 100⁰С температур хүртэл халаана.

3-р шат: 100⁰С температурт халсан тосоо ууршуулагчид татна.

4-р шат: Вакум насосыг ажилуулан ууршуулагчид доторх усны уурыг татаж аван кондинсац хийнэ.

5-р шат: Цэвэр мазутын насосыг ажилуулан ууршуулагч доторх цэвэршсэн тосыг татаж авах ба давхар шүүр /фильтр/-ээр шүүгдэн механик хольцоноос салгана.

Энэ үйл явц реакторт татсан 10 тонн ажилласан маслыг дуустал үргэлжилнэ.



Зураг 2. Үйлдвэрийн тоног төхөөрөмж, технологийн схем



Зураг 3. Үйлдвэрийн харагдах байдал



Түүхий эд халаагч сав.



Ууршуулагч. Дулааны боловсруулалтын хэсэг



Шингэн тунадас



Дулаан солилцуур



Вакум насос

Зураг 4. Үйлдвэрийн үндсэн тоног төхөөрөмж



Хаягдал тосны сав-1ш, 50м.куб



Мазутын сав-2ш

Зураг 5. Үйлдэрийн түүхий эд болон эцсийн бүтээгдэхүүн хадгалах савнууд

2. ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧИНД НӨЛӨӨЛӨХ БАЙДАЛ, ТҮҮНИЙ ҮНЭЛГЭЭ

2.1 Төслийн газарзүйн байрлал

“Ирмүүн Ойл Трейдинг” ХХК-ийн Хаягдал тос цуглуулах, тээвэрлэх, хадгалах, дахин боловсруулах” төслийн талбай нь Төв Азийн хуурай хээрийн бүсэд багтах ба эх газрын эрс тэс уур амьсгалтай, эргэн тойрон уулсаар хүрээлэгдсэн, голын хөндийд байрладаг.

Улаанбаатар хот нь Хэнтийн нурууны баруун өмнөд хэсэг, уулын ойт хээрийн болон хуурай хээрийн завсрын бүсэд, Туул голын хөндийн хойд хэсэгт Чингэлтэй (1949.7 метр д.т.д) урд талдаа Богд, баруун талдаа Сонгино хайрхан (1652.3 метр д.т.д), зүүн талдаа Баянзүрх (1845,5 метр д.т.д) уулсаар хүрээлэгдэн зүүнээс баруун тийш сунаж тогтсон хэлбэртэй байрлана. Газрын үнэмлэхүй өндөр далайн түвшнөөс дээш 1300-1400 метрийн хооронд зонхилон байрлах бөгөөд хамгийн нам газар нь Туул голын эрэг сонгино орчим 1200 метр орчим байхад хамгийн өндөр цэг Богд уулын Цэцээ гүн оргил далайн түвшинөөс дээш 2256,3 метр байна.

2.2 Уур амьсгалын үндсэн үзүүлэлтүүд

Уур амьсгалын хувьд Монгол орон нь Сибирийн сөрөг циклоны нөлөөнд орших тул эх газрын эрс тэс, ширүүн уур амьсгалтай өвөл тэсгим хүйтэн, зун халуун, агаарын хоног, сар, улирлын температурын хэлбэлзэл ихтэй, агаарын жилийн температур хасах утгатай, хур тунадас бага, цасан бүрхүүл ялимгүй бага, чийг ямагт дутмаг, өвөлдөө салхигүй тогтуун, хавартаа салхи ихтэй, нарны гийгүүлэлтийн үргэлжлэх хугацаа урт байх онцлогтой.

2.3 Төсөл хэрэгжих орчны гадаргын болон гүний усны төлөв байдал

Тус судалгааны талбай нь Туул голын сав газарт оршино. Туул гол нь Хан Хэнтий нурууны салбар уулс болох д.т.д 2000 м өндөрт өргөгдсөн Чисаалайн сарьдаг, Шороотын давааны өврөөс гарах Намъяа, Нэргүй хэмээх хоёр голын уулзвараас эх авна. Туул голын жилийн дундаж өнгөрөлт Улаанбаатар орчим 26.6, Сонгинод 25.8, Өндөрширээтэд 24.1 шоо м/с байна. Голын ус хурах талбай 48909.2 ам км, урт нь 898 км юм. Ус хагалбарын шугамын урт 2055.6 км, түүний дундаж өндөр 1719.0 м, голуудын нийлбэр урт 11046.5 км, усан сүлжээний нягтшил 0.23 км/км², ус хурах талбайн дундаж өндөр 1300.0 м, хөндийн гүн дунджаар 559.0 м, түүний өргөн 54.4 км. Туул голын өргөн нь жирийн үед 35-75 м, гүн нь 0.8-3.5 м, урсгалын хурд 0.50-1.50 м/с болно.

Туул голын ус хурах савын хэмжээнд 44013 ам км талбайд жилд 810 сая шоо метр газрын доорхи усны нөөц баялагтай байж болох тооцоо байдаг. Ай савын хэмжээнд тархсан хурдас чулуулгийн нас, литилогийн төрлийг нэлээд ерөнхийлөн нэгтгэр, тэдгээрийг нүх сүвшилт зонхилсон, эсвэл ан цавшилт зонхилсон байдлаар ангилж, газрын доорхи усны судлагдсан түвшин, хөдөлгөөны төрх зэрэг практикийн болон онолын шинжтэй хүчин зүйлсийг харгалзан уг ай савын хэмжээнд ус агуулагч нүх сүвэрхэг 10 бүрдэл, ус агуулагч ан цавлаг 5 бүсийг ялгаж, газрын доорхи усны 1 ам километр байж болох нөөц баялагаар нь 1) 50 л/с-ээс дээш буюу их нөөц баялагтай, 2) 5-50 л/с буюу дунджаас их нөөцтэй, 3) 0,1-5 л/с буюу дундаж, 4) 0.1-0.3 л/с буюу дундаж хүртэл, 5) 0,03-0,3 л/с буюу бага, 6) 0,033-0,03 л/с буюу тун бага, 7) 0,003 л/с буюу үндсэндээ усгүй гэсэн долоон төрөлд хуваадаг.

2.4 Төсөл хэрэгжих орчны хөрсөн бүрхэвч

Улаанбаатар хот нь хөрсний газарзүйн мужлалтаар хөрс-био уур амьсгалын Хангайн их мужийн Хэнтийн өмнөх тойрогт багтах бөгөөд Туул голын өргөн хөндий, Хэнтийн нурууны салбар уулын энгэр хажуугаар ихэвчлэн хар шороон, хүрэн шороон хөрс зонхилно. Улаанбаатар хотын нутаг дэвсгэр нь хөрс-газарзүйн мужлалтаар, хөрсний өндрийн бүсшилийн субгумид хэв шинж бүхий Хэнтий орчмын 52, 43-р тойргуудад хамаарагдана. Хөрсний ялзмагийн агууламж хэв шинжээс хамааран харилцан адилгүй бол урвалын орчин сул хүчиллэг, нийт хөрс тодорхой хэмжээгээр карбонат агуулсан, 10-20% хүртэл чулуурхаг, элсэнцэр хөнгөн шавранцар механик бүрэлдэхүүнтэй элс, тоосон фракц зонхилж шаврын эзлэх хувь бага.

“Хаягдал тос цуглуулах, тээвэрлэх, хадгалах, дахин боловсруулах” төслийн байршил нь хот суурин газар байрладаг тул тухайн орчинд хотжилт барилгажилтын нөлөөгөөр хөрс дарагдаж, элэгдэл эвдрэлд орсон байна. Төслийн талбай нь нийт 0.4 га бөгөөд нийт талбайд хөрсний үржил шимт давхарга байхгүй болж ургамлан бүрхэвч устсан төлөв байдалтай. Хээрийн судалгаагаар нийт талбайд 1 цэг сонгон авч хөрсний судалгаа хийхэд төслийн талбайн хөрс нь сул шүлтлэгээс шүлтлэг урвалын орчинтой, карбонатын агууламж бага, ялзмагийн агууламж дундаж, цахилгаан дамжуулах чанар бага буюу давсжилтгүй, хөдөлгөөнт фосфор, калийн хангамж дунд зэрэг. Хөрсний үржил шимийн ерөнхий түвшин дундаж байна. Хөрсний хээрийн судалгаагаар хүнд металлын бохирдол илрээгүй боловч микробиологийн бохирдол буюу гэдэсний бүлгийн нян илэрсэн тул бохирдолтой хөрсний ангилалд хамаарч байна. Иймд төсөл хэрэгжүүлэгч нь байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланд

тусгагдсан хөрсний үржил шимийг сайжруулах, нөхөн сэргээх, бохирдлыг бууруулах зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах шаардлагатай.

2.5 Төсөл хэрэгжих орчны ургамлан нөмрөг

Төсөл хэрэгжиж буй газар нь Монгол орны ургамал газарзүйн мужлалаар Голоарктикийн их муж, Евроазийн мужийн Төв Монголын хошууны Монгол Дагуурын уулын ойт хээрийн тойрогт багтана. Энэ тойрог нь Монгол орын нутаг дэвсгэрийн 6.62%-ийг эзлэх бөгөөд 946 зүйлийн гуурст ургамал бүртгэгдсэн томоохон тойргийн нэг юм. Ургамлын аймгийн хувьд Дагуурын ойн ба уулын хээрийн төлөөлөгчдөөс, өмнөд захаараа монголын хээрийн төлөөлөгчдөөс бүрдэл болно. Ургамлан нөмрөгт хээрийн хэвшинж давамгайлах учир экологийн даацын хувьд тийм ч өндөр биш. Ургамлан нөмрөгийн 22.5% нь 35%-иас бага, 35.5% нь 50%-иас бага тусгал бүрхэцтэй байна.

“Ирмүүн Ойл Трейдинг” ХХК-ийн эзэмшил газар нь Улаанбаатар хотын суурьшилын бүсэд байрладаг бөгөөд тухайн орчны ургамлан бүрхэвч утсан ба төслийн хашаан дотор барилга зам талбайд ургамлан бүрхэвч дарагдсан, машин техникийн нөлөөгөөр ургамлан бүрхэвч талхлагдсан, хайрга дэвссэн, хатуу хучилт хийсэн төлөвтэй байна. Улаанбаатар хотод хийгдсэн ургамалжилтын судалгаа, төслийн талбай орчимд хийгдсэн судалгаанаас харахад төслийн талбайд үетэн, алаг өвс голлосон 30-40 хувийн бүрхэцтэй, ургамал хоорондын нягтрал бага, хучлагагүй халцгай газрын эзлэх хэмжээ их байсан байна.

Төслийн талбайд модлог ургамал, байгалийн ургамалтай талбай байхгүй болж үйлдвэрийн хашааны ёроолоор бага хэмжээний талбайд малд идэмжгүй, тэжээмж муутай ургамал энд тэнд тархалттай ургасан байна.

2.6 Төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн тусгай хамгаалалттай газар нутаг

Төсөл хэрэгжиж буй Улаанбаатар хот нь Дархан цаазат Богдхан уулын ар хормойгоор оршдог. Богдхан уул нь 1778 онд Богд хаант Монгол Улсын үед дархлагдаж байсан, дэлхийн хамгийн анхны Дархан цаазат газар юм. Богдхан уулыг УИХ-ын 1995 оны 26 дугаар тогтоолоор Богдхан уулын дархан цаазат газар хэмээн нэрлэж, 1996 оны 05 дугаар сард ЮНЕСКО-оос Дэлхийн шим мандлын сүлжээнд оруулах шийдвэр гарч, 1997 онд гэрчилгээг олгож байв. Богдхан уулын дархан цаазат газар нь хойд талаараа нийслэл Улаанбаатар хотын Хан-Уул, Баянзүрх дүүрэг, урд талаараа Төв аймгийн Зуунмод, Сэргэлэн сумтай хил залгадаг, нийт 41.6 мян.га талбайтай, үүнээс онгон бүс газар нутгийн 17.3% буюу 7115.3 га, хамгаалалтын бүс нь 54.2% буюу 22291.9 га, хязгаарлалтын бүс 28.5% буюу 11721.8 га тус тус эзэлдэг.

3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

№	Байгалийн бүрэлдэхүүн	Үзүүлэх сөрөг нөлөөллийн товч тодорхойлолт	Бууруулах арга хэмжээний товч тодорхойлолт
1	Агаар орчин	-Хаягдал тосыг ачиж буулгах хэсэг, агуулах, хэсэг зэрэгт дуу чимээ, тоосжилт үүсэх; -Тээвэрлэлтийн машин техникээс хорт хий ялгарах; -Хог хаягдлыг ил задгай хаяснаар органик бохирдол үүсч агаар орчинд хорт хий ялгарч болзошгүй;	-Тоосжилт болон дуу чимээ бууруулах технологи ашиглах; -Агаар бохирдуулагч тоосжилт, хорт хийнүүдийн хэмжилт судалгааг тогтмол хийж, хяналт тавих; -Тээврийн хэрэгслээс ялгарах хорт хийг бууруулах; -Машин паркын талбай, зам талбайг хатуу хучилттай болгох;
2	Хөрс, ургамлан бүрхэвч	-Төслийн эзэмшлийн талбай нь барилга байгууламж, зам талбайд дарагдаж хөрсний үржил шимт нөөц багассан; - Хог хаягдлыг ил задгай хадгалах; -Машин техникийг зориулалтын бус газар парклах, засвар үйлчилгээ хийх; -Үйл ажиллагаанаас үүсэх тоосжилт нь хөрсний гадаргад бохирдлын давхарга үүсгэнэ, ургамал ургалтад сөргөөр нөлөөлнө;	- Үйлдвэрийн эргэн тойронд болон үйлдвэрийн хашааны захаар ногоон байгууламж байгуулах; -Хөрсний бохирдлоос сэргийлж хог хаягдлын менежмент хэрэгжүүлэх; -Мод, бут тариалж орчныг тохижуулах; -Хатуу шингэн хог хаягдал түр хадгалах цэгт ариутгал халдваргүйжүүлэлтийг дулааны улиралд тогтмол хийж байх;
3	Усан орчин	-Төслийн талбай орчимд гадаргын ус байхгүй; -Ахуйн хэрэглээнд гүний худаг ашигладаг;	Төсөлд ашиглаж буй гүний усыг зүй зохистой ашиглах, усны хэрэглээг тоолуурын системээр хянаж, ус ашигласны төлбөрийг хугацаанд нь төлөх зэрэг арга хэмжээ авч ажиллах нь чухал юм.
4	Амьтны аймаг	Төслийн талбай нь хот суурин газар байрладаг тул зөвхөн хүнд ойр амьтад ажиглагдана;	-Барилга байгууламжид хүнд ойр шувууд үүрээ засах, мэрэгч амьтад үүрлэхээс урьдчилан сэргийлэх; -Хог хаягдлыг битүүмжлэлтэй саванд хадгалах;
5	Нийгэм, эдийн засаг	Ард иргэд төсөлтэй холбоотой янз бүрийн санал, гомдол гаргаж болзошгүй;	Төслийн үйл ажиллагаа эхэлснээр ажлын байр нэмэгдэх, төслийн зорилгын хүрээнд таатай орчин бий болно;

4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ 2024 ОНЫ ГОЛ ЗОРИЛТ

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, үйл ажиллагааг зүй зохистой явуулах, БОННҮнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх үндсэн зорилго бүхий эрхзүйн баримт бичиг юм.

Төсөл хэрэгжүүлэгч иргэн, хуулийн этгээд нь байгаль орчныг хамгаалах талаар хүлээсэн үүргээ биелүүлж байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх үүрэг хүлээнэ.

Төслийн үйлдвэрлэлийн бүх үе шатны үйл ажиллагаанаас хүрээлэн буй орчны бүрэлдэхүүн хэсэг болох ус, ургамал, агаар, амьтан, хөрсөн бүрхэвчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, нөлөөллийн бүсэд орших айл өрх, үйлдвэрт ажиллаж буй ажилчдад ээлтэй үйл ажиллагаа явуулах зорилгоор 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулж хэрэгжилтийг ханган ажиллах зорилготой.

5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Гол ба болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэм жих нэгж	Нэгжийн зардал (төгрөг)	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8	9
1	Реакторын галлагааны үед мазут ашиглах учраас агаар орчинд утаа, хорт хий ялгарна.	Нийслэлийн агаар орчны бохирдолтой тэмцэх газартай хамтран зөвлөмжийн дагуу зуухны янданд агаар шүүгч байршуулах	Үйлдвэрийн байр	ш	1,200.0	1	1,200,000.0	2024	Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэм хэмжээ. Техникийн ерөнхий
2	Тээвэрлэлтийн явцад автомашины хөдөлгүүрийн шаталтаас агаарын чанарт нөлөөлөх	Автомашинд хөдөлгүүрийн утаа хаях хэсэгт шүүлтүүр суулгах	Үйлажиллагаанд ашиглах тээврийн хэрэгсэлүүд	ш	80,000.0	1	80,000.0	Жилд удаа 1	шаардлага MNS 5885:2008 MNS 4585:2016
3	-Машин механизм, түүний тээвэрлэлт, засвар үйлчилгээний газарт бохирдол үүсэх, шатах, тослох материал, нефтийн бүтээгдэхүүн хөрсөнд нэвчиж хөрс бохирдуулах -Аюултай хог хаягдлын асгаралт үүсэх	Үйлдвэрт ашиглах аюултай хог хаягдал, эцсийн бүтээгдэхүүн, шингэн хаягдал зэргийн асгаралтаас урьдчилан сэргийлэх, асгаралтыг цэвэрлэх багаж тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг хангах.	Үйлдвэрийн орчинд, шаардлагатай цэгүүдэд	ш	1,500.0	1	1,500,000.0	Жилд удаа 1	Үйлдвэрийн ХАБ-ын дүрэм

Нийт						2,780,000.0		
------	--	--	--	--	--	-------------	--	--

6. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8	9
1	Үйлвэрийн талбайд ногоон байгууламж цэцэрлэгжүүлэлт хийж үзэгдэх байдал болон орчны тохижилтыг нэмэгдүүлэх	Ногоон байгууламж байгуулж тодорхой хэмгийг зүлэгжүүлж олон наст болон модлог ургамлаар тохижуулах	Үйлдвэрийн оффисын цонхны доор	М ²	4	100,000.0	400,000.0	Жилд 1 удаа	
	Нийт						-		

Үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл 2024 оны 04-р сарын 25-ны өдөр гарсан ба үйлдвэрийн үйл ажиллагааг эхлүүлэх бэлтгэл ажлыг хийж байгаа тул 2024 оны тэрбум мод хөтөлбөрийн суулгацуудыг 2025 оны БОМТ-д тусган нөхөн төлөвлөн, суулгахаар төлөвлөв.

7. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Төслийн талбай, үйл ажиллагаанд өртөх түүх, соёлын өв төслийн талбай, үйлдвэрийн байрны ойр орчимд байхгүй.

8. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8
1	Болзошгүй осол, саатал, техник технологийн шугам сүлжээний гэмтэл, галын гэнэтийн аюул үүсэх	-Галын аюулаас урьдчилан сэргийлэх, байгаль орчныг хамгаалах арга хэмжээний талаар сургалт, зохион байгуулах.	Бүх ажилчид	1	500,000.0	500,000.0	Жилд 1 удаа	Монгол улсын “Галын байдлын тухай хууль”, “Аж ахуйн нэгж байгууллагад дагаж мөрдөх галын аюулгүйн дүрэм”-
2	Байгалийн гэнэтийн аюул осол	-Галын аюулгүй байдлын тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн, бэлэн байдлыг хангах.	Шаардлагатай газруудад тоног төхөөрөмж байршуулах, шинэчилж байх	1	950,000.0	950,000.0		
	Нийт					1,450,000.0		

9. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8	9
1	Ахуйн	Хог хаягдлын ангилан ялгалтын 3	Үйлдвэр, оффис	-	260,000.0	1	260,000.0	Үйл ажиллагааны	-Ариун цэврийн

Сонгинохайрхан дүүргийн 20-р хорооны нутагт орших “Хаягдал тос цуглуулах, тээвэрлэх, хадгалах, дахин боловсруулах үйлдвэр”
төслийн 2024 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

		төрлийн савнууд байршуулах.						туршид	тухай хууль -Хог хаягдлын тухай хууль
2	Үйлдвэрийн	Хатуу болон шингэн хаягдын цэгт ариутгал халдваргүйжүүлэлт хийх	Үйлдвэр	-	200,000.0	2	400,000.0	Жилд 2 удаа	тухай хууль -Хог хаягдлын тухай хууль
3	Аюултай	-Үйлдвэрээс гарах үнс, механик хольцоос салгаж буй мазутын шүүрнээс гарах хаягдал зэрэг хатуу аюултай хог хаягдал - Керосин, ууршилтаас үүссэн шингэн тунадас зэрэг шингэн аюултай хог хаягдал түр хадгалах тусгай цэг байгуулах.	Хатуу хучилттай, битүүмжлэлтэй, хашаажуулсан, хаяг шошготой стандартын шаардлага хангасан аюултай хог түр хадгалах цэг	ш	3,500,000.0	1	Үйл ажиллагааны зардалд орсон	Үйл ажиллагааны туршид	-Хог хаягдлын тухай хууль -Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль -Химийн бодисын аюулгүй ажиллагааны дүрэм
	Нийт						660,000.0		

10. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	тайлбар	Баримтлах стандарт, арга, аргачлал
	1	2	3	4	5	6	7	8
1	Агаарын тоосжилт (PM 2.5, PM 10) Агаарын бохирдуулагч бодис (SOx, NOx, COx гэх мэт)	Бохирдол үүсэж болзошгүй тухайлсан 1 цэгээс агаарын чанарыг хэмжих багажаар	Жилд 2 удаа	2	100,000.0	200,000.0	Итгэмжлэгдсэн лабораторид шинжлүүлэх	MNS 5820:2008
2	Ерөнхий химийн шинжилгээ болон хүнд элемент	Үйл ажиллагаанд ашиглаж буй худаг	Жилд 2 удаа	2	150,000.0	300,000.0		MNS 5820:2008
3	Ерөнхий химийн шинжилгээ болон хүнд элемент (Pb мг/кг, Al %, Ca % гэх мэт)	2 цэгээс буюу нийт хүнд элементийн агууламжийн дээж 2 ширхэг	Жилд 2 удаа	2	35,000.0	70,000.0		MNS 5820:2008
4	Хаягдал тосны хими, физик шинжилгээ	Цуглуулсан хаягдал тос	Жилд 1 удаа	1	Үйл ажиллагааны Зардал орсон			БОАЖ-ын сайдын 2018 оны А/18 тушаалын 1 дүгээр хавсралт
5	Хаягдал шингэн тунадасны найрлага, хими, физик шинжилгээ	Үйлдвэрээс гарах хаягдал шингэн тунадас		1				
6	Мазутын хими, физик шинж чанарын шинжилгээ	Үйлдвэрийн эцсийн бүтээгдэхүүний чанарыг		1				
	Нийт					570,000.0		

**11. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН
БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцоолсон төсөв	Хэрэгжүүлэх хуваарь			Хариуцсан албан тушаалтан
			2024 он			
			10 сар	11 сар	12 сар	
1	Байгаль хамгаалах ажлын төлөвлөгөөг хэрэгжүүлэх;	70,000.0	+			Үйлдвэрийн дарга
2	Болзошгүй осол аюулын үед орон нутгийн эмнэлгийн болон бусад холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах талаар тохиролцож гэрээ байгуулж ажиллах;	-	+			Үйлдвэрийн дарга
3	Ажлын байр, зам талбайд ХАБЭА-ны ба замын хөдөлгөөний дүрмийн тэмдэг, дохио тэдгээрийн хэрэгжилтийг хянах;	600,000.0		+		ХАБ-ын ажилтан
4	Төсөл хэрэгжиж буй орон нутгийн захиргаанд байгаль орчныг хамгаалах талаар хэрэгжүүлж буй үйл ажиллагааны хэрэгжилтийн талаар тайлагнах;	150,000.0		+		Үйлдвэрийн дарга
5	Галын аюулгүй байдлын дүгнэлтийг дүүргийн онцгой байдлын хэлтсээс гаргуулах;	-		+		Үйлдвэрийн дарга

6	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнах төлөвлөгөө	100,000.0				
	Нийт	920,000.0				

12. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	БОМТ, БОМТ-ний хэрэгжилтийг тайлагнах талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацаа тов	Тайлагнах зардал, төг	Хариуцан зохион байгуулах тушаалтан	Зохион байгуулах газар
1	Төсөл хэрэгжүүлэгч	Уулзалт	2024 оны БОМТ-ний хэрэгжилт	2024 оны 11 сар	Удирдлага зохион байгуулалтын зардалд орсон	Үйлдвэрийн дарга	Хорооны иргэний танхим

2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ НИЙТ ЗАРДАЛ

№	Байгаль орчны менежментийн үйл ажиллагаа	Нийт зардал
1	Сөрөг нөлөөллийг бууруулах менежментийн төлөвлөгөө	2,780,000.0
2	Ногоон байгууламж, тэрбум мод хөтөлбөрийн төлөвлөгөө	-
3	Осол эрсдлийн менежментийн төлөвлөгөө	1,450,000.0
4	Хог, хаягдлын менежментийн арга хэмжээний зардал	660,000.0
5	Орчны хяналт, шинжилгээний хөтөлбөр	570,000.0
6	Удирдлага зохион байгуулалтын ажлын зардал	920,000.0
	2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал	6,780,000.0

ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛСАН: “ИРМҮҮН ОЙЛ ТРЕЙДИНГ” ХХК